

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Баянгол дүүргийн Ариун чанар ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/087/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 11315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-15 № 679
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
АРИУН ЧАНАР ӨЭМТ-ИЙН ДАРГА
Б.УРАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Ариун чанар ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тус эрүүл мэндийн төв нь Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас дархлаажуулалтын зардалд 2.2 сая төгрөг, Эрүүл мэндийн газраас 3.6 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 4 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлж гүйцэтгэлээр 519.7 сая төгрөг, нийт 513.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Ариун чанар ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 90.4 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,001,394.59	2,739,193.45
1.1.4	Бусад авлага	22,537,014.55	15,702,092.39
1.1.6	Бараа материал	7,999,015.00	2,883,487.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	37,537,424.14	21,324,772.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	208,666,750.90	161,070,060.35
1.2.1.1	Барилга	28,382,780.00	-
1.2.1.2	Хуримтлагдсан элэгдэл	(21,287,085.12)	-
1.2.1.3	Машин тоног төхөөрөмж	256,942,935.60	224,630,801.20
1.2.1.4	Хуримтлагдсан элэгдэл	(105,977,342.92)	(108,355,877.75)
1.2.1.5	Тээврийн хэрэгсэл	38,500,000.00	38,500,000.00
1.2.1.6	Хуримтлагдсан элэгдэл	(11,040,000.00)	(16,269,999.96)
1.2.1.7	Тавилга эд хогшил	32,447,361.90	36,901,160.00
1.2.1.8	Хуримтлагдсан элэгдэл	(11,973,578.56)	(14,336,023.14)
1.2.1.9	Бусад үндсэн хөрөнгө	2,671,680.00	-
1.2.1.10	Хуримтлагдсан элэгдэл	-	-
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	208,666,750.90	161,070,060.35
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	246,204,175.04	182,394,833.19
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	9,118,910.16	16,517,229.22
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,118,910.16	16,517,229.22
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,118,910.16	16,517,229.22
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч	75,396,797.00	75,396,797.00
2.3.1.1	Төрийн	75,396,797.00	74,882,297.00
2.3.1.2	Хувийн	-	514,500.00
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	24,075,066.00	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	137,613,401.88	90,480,806.97
2.3.10	Эздийн өмчийн дүн	237,085,264.88	165,877,603.97
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	246,204,175.04	182,394,833.19

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	631,536,144.34	513,911,158.40
2	Борлуулалтын өртөг	567,317,501.83	582,943,935.88
3	Нийт ашиг (алдагдал)	64,218,642.51	(69,032,777.48)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	64,218,642.51	(69,032,777.48)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	64,218,642.51	(69,032,777.48)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,218,642.51	(69,032,777.48)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,396,797.00	24,075,066.00	73,394,759.37	172,866,622.37
Тайлант үеийн үр дүн			64,218,642.51	64,218,642.51
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,396,797.00	24,075,066.00	137,613,401.88	237,085,264.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			24,075,066.00	24,075,066.00
Залруулсан үлдэгдэл	75,396,797.00	24,075,066.00	161,688,467.88	261,160,330.88
Өмчид гарсан өөрчлөлт		(24,075,066.00)	(2,174,883.43)	(26,249,949.43)
Тайлант үеийн үр дүн			(69,032,777.48)	(69,032,777.48)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,396,797.00		90,480,806.97	165,877,603.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	527,166,828.79	530,199,326.84
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	527,166,828.79	530,199,326.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	519,587,083.48	525,286,622.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	360,670,428.47	383,764,577.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	45,763,319.87	53,185,423.77
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	82,249,175.14	45,731,625.01
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	30,904,160.00	42,604,996.98
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,579,745.31	4,912,703.86
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,008,000.00	9,174,905.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,008,000.00	9,174,905.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,008,000.00)	(9,174,905.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,428,254.69)	(4,262,201.14)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,429,649.28	7,001,394.59
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,001,394.59	2,739,193.45

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 3,757.6 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн дансанд үлдэх өртөггүй 3 ширхэг хөрөнгөд 639.7 мянган төгрөгийн элэгдэл тооцсон байна.	1	639.7			1	639.7	1	639.7				
Бараа материал дансанд 5,918.2 мянган төгрөгийн 9 ширхэг үндсэн хөрөнгө байна.	1	5,918.2			1	5,918.2	1	5,918.2				
Нөхөрлөлийн дүрмийн сангийн 514.5 мянган төгрөгийг хуримтлагдсан ашгийн дансанд бүртгэсэн байна.	1	514.5			1	514.5	1	514.5				
Дүн	3	7,072.4			3	7,072.4	3	7,072.4				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 1,064.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 450.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 614.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, 614.0 мянган төгрөгийн ахуйн материал, тослох материал, хэрэгсэл худалдан авч нөөцөлсөн байна.	1	614.0			1	614.0						
Төвийн даргын 2025 оны А/18, А/23 дугаар тушаалын дагуу хагас жил болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч, тооллогын бүртгэлгүй, тооцоо нийлж, баталгаажуулаагүй, тайлагнаагүй байна.	1	-			1	-						
Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооноос зохион байгуулсан уралдаан, тэмцээнд 450.2 мянган төгрөгийг нотлох, дэмжих баримтгүй зарцуулсан байна.	1	450.2	1	450.2								
Дүн	3	1,064.2	1	450.2	2	614.0						

² Хүнин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 зөрчил илэрч, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
1	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "Хүүхдийн баяр" заалтыг үндэслэн ӨЭМТ-ийн даргын Б/11 дүгээр тушаалаар ажилтнуудын хүүхдүүдэд зориулж бэлэг, хүлээн авалт зохион байгуулж 1,275.5 мянган төгрөгийг БГБХН-ийн тогтоол болон хурлын тэмдэглэлгүй зарцуулсан байна.	1	-								1	-
	Дүн	1	-								1	-